

МОНГОЛ УЛС, БНСУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

И.Энхболд
ШУА-ийн Олон улсын
харилцааны хүрээлэн
Судлаач

Монгол-Солонгосын хооронд хоёр мянга гаруй жилийн тэртээ Хүннү гүрний үеэс харилцаа үүсэж тогтсон хэмээн түүхчид үздэг. Хятан гүрний үед Солонгос орноос монгол хэл сургахаар оюутнуудаа илгээж байсан тухай сурвалжийн мэдээ буй. XIV зууны сүүл үеэс ХХ зууны эхэн үе хүртэл 500 гаруй жилийн урт хугацаанд Монгол, Солонгосын улс төр, эдийн засаг, соёлын харилцааны түүхэнд холбоотой тэмдэглэгдэн үлдсэн зүйлс ховор байна. 1980-аад оны сүүл, 1990-ээд оны эхэнд хоёр орны хэвлэл мэдээллээр харилцан бие биенийхээ тухай бичиж эхэлсэн баримтууд байдаг. Ялангуяа түүх, археологи, хэл шинжлэл, улс төр, эдийн засаг, олон улсын харилцааны талаар өгүүлэл нийтлэл олноор хэвлэгдсэн байна. Нэг үгээр хэлбэл Монгол, Солонгос орнуудад бие биеэ харилцан танин мэдэх сонирхол ихээхэн байсан нь тодорхой.

1990 оны 3 дугаар сарын 26-нд манай санаачлагаар ямар нэгэн болзолгүйгээр БНМАУ, БНСУ-ын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоосон билээ. Энэ нь ЗХУ-ын оролцоогүйгээр манай улсаас бие даан БНСУ-тай албан ёсны дипломат харилцаа тогтоосон үйл явдал болсон бөгөөд Азийн социалист улсуудаас хамгийн анх дипломат харилцаа тогтоосон гэдэг утгаараа ихээхэн онцлогтой байсан юм.

Хоёр улсын хооронд албан ёсны харилцаа тогтсоноос хойш 26-хан жил өнгөрч байгаа ч хил залгаа болон газар нутгийн хувьд илүү ойрхон орнуудыг бодвол маш гүнзгий харилцаа тогтсон. Улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, шашин, нийгэм, эрүүл мэнд зэрэг бүх салбарт монголчууд, солонгосчууд харилцан бие биеэ таатайгаар хүлээн авч бусдаас илүү ойлгон дэмжиж байсны илрэл гэлтэй.

Улмаар 1992 онд БНСУ-ын Ерөнхийлөгч Ро Дэ Ё, 1999 онд Ким Дэ Жүн, 2006 онд Ну Му Хён, 2011 онд И Мён Пак, 2016 онд Пак Гын Хэ нар Монгол улсад тус тус албан ёсны айлчлал хийв. Монгол улсын талаас 1991 онд Ерөнхийлөгч П.Очирбат, 2001 онд Н.Багабанди, 2007, 2008 онд Н.Энхбаяр, 2016 оны 5 дугаар сард Ц.Элбэгдорж БНСУ-д албан ёсны айлчлал хийсэн.

2013 оноос ЗХА-ын аюулгүй байдлын талаарх “Улаанбаатарын хэлэлцээ” эхлүүлж, АНУ, ОХУ, БНСУ, БНАСАУ, БНХАУ, Япон зэрэг олон улсын хэмжээнд

яригдах чухал санаачлага болсон. Энэ нь ЗХА-ын аюулгүй байдлыг хангахад дөхөмтэй төдийгүй хоёр Солонгосын нэгдэлд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

Дээр дурдсанчлан, хоёр орны улс төрийн харилцааны хувьд өндөр дээд хэмжээний харилцаа тогтмолжиж ирлээ. Монгол улс нь БНХАУ, ОХУ, Япон улстай Иж бүрэн түншлэлийн харилцаатай бол БНСУ-тай стратегийн түншлэлийн харилцаа тогтоох талаар өдгөө яригдаж эхлэх боллоо.

Эдийн засгийн харилцаа

Монгол улс, БНСУ-ын эдийн засгийн харилцаа өнгөрсөн 26 жилийн хугацаанд харилцан идэвх чармайлтаар дүүрэн байж, харилцаа тогтсон эхний жил буюу 1990 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн хоёр орны төр засгийн тэргүүнүүд олон санал, санаачлагыг харилцан дэвшүүлжээ. Тухайлбал, Сайд нарын Зөвлөлийн дарга Ж.Гунгаадорж, МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн дарга, ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэн, Төлөвлөгөө эдийн засгийн улсын хорооны нэгдүгээр орлогч дарга, Төрийн сайд Т.Намжим, ЭЗГХХЯ-ны орлогч сайд Ц.Молом, ШУТДБУХ-ны орлогч дарга Ц.Сэджав, Зам тээврийн орлогч сайд, Иргэний агаарын тээврийн удирдах газрын дарга Д.Сүрэнхорлоо, Соёлын яамны орлогч сайд Д.Нарантуяа нар бүгд нэгэн санаагаар дараах саналыг тавьж байсан тухай түүхэн баримт Гадаад харилцааны яамны Гадаад харилцааны төв архивт хадгалагдаж үлдсэн байдаг.

Үүнд, худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, соёл, жуулчин, иргэний агаарын тээвэр, зэс, молебдин, цайр, газрын ховор элемент олборлох, баяжуулах, боловсруулах, бага оврын машин тоног төхөөрөмж угсрах, зарим эд анги метал хийцийг угсрах, үйлдвэрлэх, үйлдвэрийн зохиулалттай төрөл бүрийн цавуу, химийн мяндас гаргаж авах, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай хөнгөн үйлдвэрийн гаралтыг нэмэгдүүлэх, электрон тоног төхөөрөмж угсрах, түүний суурь материал бэлтгэх, хамтарсан үйлдвэр байгуулах, газар тариалан, коксжих нүүрс худалдах, тээврийн 3 талт хэлэлцээ байгуулах, Солонгос барааг Монголоор дамжуулан Европийн зах зээлд гаргах, ШУТ, мэдээллийн салбарт хамтрах, соёлын солилцоо хийх, жуулчид хүлээн авах зэрэг асуудал багтаж байв.

Дээрх албаны хүмүүсийн БНСУ-ын талд тавьсан үндсэн санааг нэгтгэн дүгнэвээс дараах 3-н үндсэн санаа гарч байна. Үүнд: 1. Хамтарсан үйлдвэр барих. 2. Байгалийн баялаг ашиглах. 3. Шинжлэх ухаан техникийн харилцаа холбоог хөгжүүлэх явдал байв.

Өнгөрсөн 25 жилийн хугацаанд Монгол улс, БНСУ-ын эдийн засгийн харилцаа


хурдацтай хогжсоор ирлээ. БНСУ-ын талаас ихэвчлэн хувь хүмүүс, компаниуд, олон нийтийн байгууллагынхан Монголд олноороо ирж ажиллах болсон бөгөөд нийтийн хоол, үйлчилгээ, зочид буудал, барилга, зам гүүр болон уул уурхайн салбарт хөрөнгө оруулсан байна.

2016 оны 7 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Монгол улсын Ерөнхийлөгчийн урилгаар БНСУ-ын Ерөнхийлөгч айлчилсан. Энэ үеэр 4.8 тэрбум ам.долларын хөнгөлттэй зээл олгох Санамж бичигт хоёр тал гарын үсэг зурлаа. Үүнээс 2.7 тэрбум ам.доллар нь эрчим хүчний салбарт хэрэглэгдэх юм.

Айлчлалын хүрээнд БНСУ-ын 109 компанийн төлөөллөөс 62 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, 11 томоохон үйлдвэрлэгчид болон бусад төрийн байгууллагын 36 төлөөлөгч Монгол улсад хүрэлцэн ирсэн. Айлчлалын бүрэлдэхүүнд БНСУ-ын дэлхийд тэргүүлэгч компаниуд болох “LG Electronics”, “Samsung Electronics”, “Hyundai Motor”, “Hanwha” зэрэг группын төлөөлөл багтжээ. БНСУ-ын био технологи, эрүүл мэндийн салбарын 18 компани, түүхий эд, жижиглэн худалдааны 16 компани, машин тоног төхөөрөмж нийлүүлэгч 12 компани, үйлдвэрлэл, инженерийн 6 компани, эрчим хүч, байгаль орчны 4-н компанийн төлөөлөл Монгол Улсад хүрэлцэн иржээ.

Мөн БНСУ-ын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сантай 2016-2018 онд хамтран ажиллах санамж бичигт хоёр улсын Сангийн яамнаас гарын үсэг зурав. Үүнд,


1. Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл.
2. 10 аймгийн дулааны станц барих төсөл.



Сурвалж: <http://customs.gov.mn/>

БНСУ гаргасан бараа, бүтээгдэхүүний экспортын үзүүлэлтээр Монгол улсын хэмжээнд 10 дугаар байранд орж буй боловч нийт экспортын 0.2 хувийг эзэлж байна. 2015 оны экспортын огцом өсөлтөнд 10.9 сая ам.долларын үнэ бүхий молебдиний баяжмал, 46 сая ам.долларын үнэ бүхий зэсийн баяжмал экспортлож эхэлсэн нь 2015 оны үзүүлэлтийг өсгөх гол хүчин зүйл болжээ. Нийт

56.9 сая ам.долларын үнэ бүхий молебдин, зэсийн баяжмалыг хасаж тооцвол



Сурвалж: <http://customs.gov.mn/>

БНСУ импортын үзүүлэлтээр Монгол улсын хэмжээнд 4 дүгээр байранд байгаа ба нийт импортын 6.7 хувийг эзэлж байна. 2015 оны импортын бууралтад гол нөлөөлсөн хүчин зүйл нь нефтийн бүтээгдэхүүн бөгөөд ОХУ-ын нефтийн бүтээгдхүүний үнийн бууралтаас ихээхэн шалтгаалжээ.


2015 онд нийт импорт 258 сая ам.доллар байгаагаас нефтийн бүтээгдэхүүн 28 сая ам.доллар, хөнгөн цагаан бүтэц, энд анги 26 сая ам.доллар, ачааны тэрэг 15 сая ам.доллар, бусад бараа бүтээгдэхүүн 188 сая ам.долларийг тус тус эзэлж байна.

Монгол улс, БНСУ-ын хооронд явагдсан худалдааны тэнцэлийг 1990-2015 оныг хүртэл нийтэд нь тооцож үзвэл нийт экспорт 565 сая ам.доллар, нийт импорт 3,203 сая ам.доллар, нийт худалдаа 2,638 сая ам.долларийн алдагдалтай байна. Нэмж хэлэхэд манай иргэдийн мөрийтэй тоглоомонд оруулсан мөнгө, боловсрол, эрүүл мэндийн салбарт оруулсан мөнгийг тооцож үзвэл дээрх тоо нэмэгдэх нь дамжиггүй. Энэ талаарх судалгааг цаашид анхааралдаа авч эрдэмтэн, судлаач, шинжээчид бодлогын түвшинд судлах зайлшгүй хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

Мөн 1990 онд Ерөнхий сайд Д.Бямбасүрэнд БНСУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхэт элчин сайд Квон Ён Сүн хэлэхдээ: “Хятадын төмөр замын Тянжин боомтын ачаалал их тул ачаа тээвэр нэмэх боломж бага юм. Иймд Манжуураар 450-500 км төмөр зам тавьвал Хуладао боомтыг ашиглаж болох бөгөөд Хятадын талд ч ашигтай. Монгол улсад ч 400-500 км төмөр зам барих шаардлагатай. ОУВС, АХБ зэргээс тусламж авах урьдчилсан тооцоог гаргасан байх хэрэгтэй”¹ хэмээн хоёр улсын худалдааны хөгжлийн талаар санал солилцож байсан сонирхолтой баримт байна.

¹ Монгол Улсын ГХЯ-ны Гадаад харилцааны төв архив, фонд, данс №2, ХН-112, хуудас 33

Бүртгэлтэй компанийн тоо (БНСУ-д)




<http://koreaexim.go.kr/>

Монгол улсын хэмжээнд 2 дугаар байранд орж 18 хувийг эзэлж байна.

Хөрөнгө оруулалтын хэмжээ

Мянган ам.доллараар




Сурвалж: <http://investmongolia.gov.mn/>

Хөрөнгө оруулалтын хэмжээгээр 7-р байранд орж буй боловч нийт хөрөнгө оруулалтын 2.6 хувийг эзэлж байна.

Хөрөнгө оруулалтын хэмжээ (Салбараар)

Мянган ам.доллар



Сурвалж: <http://koreaexim.go.kr/>

Энэ хугацаанд БНСУ-аас хамгийн их хөрөнгө оруулсан салбар нь Уул уурхайн салбар бөгөөд 117 сая ам.доллар, дараа нь Худалдааны салбар орох ба 69 сая ам.доллар, мөн Барилга, Үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг салбарын хөрөнгө оруулалт багтаж байна. 1994-2016 он хүртэл БНСУ-аас нийт 431 сая ам.долларын хөрөнгө оруулалт орсон нь жилд дунджаар 17 сая, сард 1.4 сая ам.долларын болж байна.

Харин уул уурхайн салбарт манай улсаас Таван толгой зэрэг олон уурхайд хамтран ажиллах санал тавьсан боловч хөрөнгө оруулалт хийж чадаагүй байна. 2013 онд хоёр орны худалдаа 500 сая гаруй ам.доллар байсан бол одоо буурч 300 сая шахам ам.доллар болсон. Сүүлийн үед энэ асуудал дээр БНСУ-ын төр засгийн зүгээс санаа зовон анхаарал хандуулах боллоо.

БНСУ-ын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангаас авсан хөнгөлттэй зээл

1992	Disposable Syringe & Needle Plant Project	Нэг удаагийн зүү, тарнуурын үйлдвэр	5.2
1996	Cogeneration Power Plant Construction Project	Дулааны цахилгаан станц	8.0
1999	Rural Telecommunications Project	Орон нутгийн цахилгаан холбоо	14.3
1999	Rehabilitation of Government Communications Network Project	Засгийн газрын холбооны сүлжээ шинэчлэл	5.3
1999	Cogeneration Power Plant Construction Supplementary Project	Дулааны цахилгаан станцын хангамж	0.9
2004	Road Development Project for Choir-Sainshand Section	Чойр-Сайншандын авто замын хөгжил	23.9
2006	Intelligence Transportation System Project	Авто замын ухаалаг систем	12.8
2006	Emergency Information Network Project	Түргэн тусламжийн мэдээллийн сүлжээ	13.5
2011	National Diagnostic and Treatment Center Project	Үндэсний эмчилгээ, оношлогооны төв	55.46
		Нийт	139.36

Эх сурвалж: <http://211.171.208.43/edcfeng/about/overview/what.jsp>

Дээрх төслүүд нь хоёр улсын Засгийн газрын хэмжээнд яриа хэлэлцээр амжилттай болж хэрэгжүүлжээ. Дээрх төслүүдийн ихэнх гүйцэтгэгч нь БНСУ-ын компани байдаг бөгөөд “Тухайн зээл авч байгаа улсдаа хэрэгжүүлэх төслийг чанартай сайн гүйцэтгэх зорилгоор ихэвчлэн БНСУ-ын компанийг сонгох сонирхол байдаг” хэмээн тайлбарладаг.

КОИСА-ийн үзүүлсэн тусламж

Detail	Төрөл	Amount
Infra	Дэд бүтэц	103,869,792
Aid In Kind/In Cash	Тусламж	2,346,112
Emergency Relief	Яаралтай тусламж	311,665
Development Study	Хөгжлийн судалгаа	9,830,707
Invitation of Trainees	Мэргэжилтэн урих	10,614,865
Experts	Зөвлөх	492,921
Medics	Эмч	502,534
Volunteers	Сайн дурынхан	37,448,327
Public-Private Partnership	Олон нийтийн, хувийн түншлэл	12,522,515
Total	Нийт	177,939,439

Эх сурвалж: КОИСА

1998 оны 7-р сарын 31-нээс 8 дугаар сарын 31 өдрүүдэд КОЙКА-гийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрыг хаах шийдвэр гарсантай холбогдуулан Элчин сайд Л.Галбадрах БНСУ-ын ГХХЯ-ны худалдаа эрхэлсэн төрийн сайдын орлогч Чон Ею Ён, КОЙКА-гийн ерөнхийлөгч Шин Ки Вок нартай тус тус уулзаж, КОЙКА-гийн төлөөлөгчийн газрыг хэвээр байлгах талаар хүсэлтээ Монгол Улсын Засгийн газрын өмнөөс тавьсан байдаг. Улмаар тухайн

оны 10 дугаар сараас эхлэн манай талын хүсэлтийг харгалзан үзэж КОЙКА-гийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрыг хаах шийдвэрээ харгалзан үзэж түүний оронд КОЙКА-гийн зохицуулагчыг Улаанбаатарт суугаа өөрийн ЭСЯ-нд томилон ажиллуулж эхэлсэн байна.²

2015 оны 2 дугаар сарын Монгол Улсын цагаачлалын албаны тоо баримтаас үзвэл Монгол улсад БНСУ-ын 2382 иргэн бизнесийн болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулан байнгын оршин сууж байна. Харин БНСУ-д Монгол улсын 25 мянган иргэн ажиллаж, амьдарч байна. Эдгээр иргэдээс Монгол улсад сарын 80-100 мянган ам.долларийн орлого ордог гэсэн зарим тооцоо байдаг. БНСУ-д ажиллаж амьдарч байсан монгол залуус тус улсын үйлдвэрлэл, технологийг нутагшуулах талаар амжилт олж байна. Тухайлбал, Солонгосын хөрөнгө оруулалттай Янмал оймсны үйлдвэр байгуулагдаж эх орны хэрэгцээг хангаад зогсохгүй ОХУ-ын Улаан-Үүд хотын хэрэгцээг ч хангаж эхэлжээ. Мөн Монгол улсад Солонгосын технологээр кимчи, хар ямааны сүү, ариун цэврийн цаас болон бусад олон төрлийн өргөн хэрэглээний барааг үйлдвэрлэж, хэрэглэгчдэд нэгэнт хүрч чадсан байна. Улаанбаатар хотод газар анх хувьчилж эхэлж байхад БНСУ-ын компаниуд хотын төвийн газруудыг ихээр нь худалдан авсан. Тиймээс БНСУ-ын компаниудын газар, орон сууц болон бусад үл хөдлөх хөрөнгө Улаанбаатар хотын төвөөр цөөнгүй бий.

2015 оны 9 дүгээр сарын сүүлчээр Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж НҮБ-д айлчлах үеэр 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр гаргах санаачлага БНСУ-ын талаас гаргасныг бид дэмжсэн. Мөн Азийн цахилгаан эрчим хүчний нийлүүлэлтэнд Монголын салхиний эрчим хүчнийг ашиглах тухай санаачлагыг БНСУ-ын тал анхааралдаа авсан байна.

БНСУ-ын Засгийн газраас 5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг Монгол улс болон Төв Азийн орнуудад хийхээр баталсан. Мөн Korean Dream буюу КД Монголд сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байна. Түүнчлэн хоёр орны харилцаанд холбогдох Евразийн сүлжээ, Түмэн гол зэрэг төслүүд яригдаж байна.

Дэлхий нийтийн анхааралд байдаг Солонгосын хойгийн асуудал нь чухамдаа хоёр Солонгосын нэгдлийн тухай асуудал юм. Үүнд, ХБНГУ-ын туршлагыг хэрэгжүүлэхээр нэг хэсэг эрдэмтэд бичиж байхад зарим нь хэрэв нэгдвэл БНСУ-ын эдийн засаг унана. Тиймээс хоёр Солонгосын нэгдэх асуудлыг Монгол загвараар, өөрөөр хэлбэл БНАСАУ-д ардчилал байгуулах, тэрхүү ардчилал нь Монгол загвартай байх ёстой гэсэн санааг дэвшүүлдэг. Энэ нь улс тор, эдийн засаг, оюун санааны өөрчлөлтийг хийнэ гэсэн үг юм. Тийм учраас Монголын ардчилал тогтоосон туршлага хоёр Солонгосын нэгдэлд их чухал гэж тэд ярьж

² Монгол Улсын ГХЯ-ны Гадаад харилцааны төв архив, фонд, данс №1, ХН-112, хуудас 3

байна.

Дүгнэлт

1. Монгол Улс, БНСУ-ын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоосон 1990 оноос хойш үе үеийн төрийн тэргүүн нар хамтарсан үйлдвэр барих, байгалийн баялагийг хамтран ашиглаж, ашиг олох, шинжлэх ухаан, технологи нэвтрүүлэх зэрэг үндсэн чиглэлийг барьж, өнөөг хүртэл БНСУ-ын талд санал, санаачлага тавьсаар иржээ. Эдгээр саналыг бодитоор хэрэгжүүлэх цаг нэгэнт болсон байна гэж судлаач миний бие үзэж байна.
2. Хоёр орны нийт худалдааны тэнцэл 1990-2015 он хүртэл -2.6 тэрбум ам.доллараар хэмжигдэж байна. Өөрөөр хэлбэл, энэ хэмжээний хөрөнгө БНСУ-д орсон гэсэн үг. Энэ байдлыг хоёр талын шийдвэр гаргах түвшнийхэн, эдийн засгийн чиглэлийн эрдэмтэн судлаачид анхааралдаа авч судлах цаг болжээ.
3. Дэлхийн түвшинд 100 сая ам.доллараас дээш хөрөнгө оруулалт орж ирсэн тохиолдолд томоохон хэмжээний хөрөнгө оруулалт гэж тооцдог. Гэвч Монгол улсад БНСУ-ын хөрөнгө оруулалт хамгийн их орж ирсэн 2008 онд нийтдээ 60 орчим сая ам.доллар байсан нь бусад орнуудын манай улсад оруулж буй хөрөнгө оруулалттай харьцуулахад чамлалттай үзүүлэлт юм. Цаашид энэ тал дээр түлхүү анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

Ашигласан бүтээл

1. И.Энхболд, “Монгол Улсад өргөнөөр яригдаж буй төслүүдийн тойм”, эрдэм шинжилгээний илтгэл, 2015.
2. “Korea-Mongolia Economic Relations: How Can They Be Reinforced?”, World Economy Brief, 2016.
3. 이 평 래, “한-몽 협력을 위한 몇 가지 제언”, 2016.
4. 이재영, 권가원, “한국과 몽골의 경제협력 현황과 증진방안”, World Economy Today, 2016.
5. www.un.int
6. www.ubinfo.mn
7. <http://customs.gov.mn/>
8. <http://www.iss.gov.mn>
9. <http://www.mfa.gov.mn>
10. <http://koreaexim.go.kr/>